

“БЭРХ УУЛ” ХК

2017 оны эхний хагас жилийн үйл ажилгааны товч тайлан

Компанийн нэр: ”Бэрх Уул” ХК

Хаяг: Хэнтий аймаг, Бэрх тосгон (Батноров сум), Уулын үйлдвэрийн байр-01

Утас: 75859505, 99092755

Улсын бүртгэлийн дугаар: 1810002001
Регистрын дугаар: 2643928
Үйл ажиллагааны чиглэл: Жонш, нүүрс олборлолт
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 108 хувьцаа эзэмшигчид 19,062,080 ширхэг хувьцааг эзэмшиж байна /2017 оны 04 сарын 24-ны өдрийн тархалтын судалгаа/

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд

Компанийн 2016 оны 2-р улирлын орлогын тайланг 2017 оны 2-р улирлын орлогын тайлангийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзвэл:

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2016оны 2-р улирал	2017 оны 2-р улирал
Борлуулалт	сая. төг	321.42	533.87
ББӨ	сая. төг	151.86	241.97
Нийт ашиг	сая. төг	169.56	291.90
Ерөнхий удирдлагын зардал	сая. төг	224.8	264.57
Санхүүгийн зардал	сая. төг	949.84	1,084.02
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	-1005.07	-1,056.69
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая. төг	-0.56	(3.33)
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	сая. төг	273.64	1,021.35
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	-731.99	(38.68)
Орлогын татварын зардал	сая. төг		
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	-731.99	(38.68)

2017 оны эхний хагас жилийн байдлаар 25.406,5 тн нүүрс борлуулж 533,87 сая төгрөгийн орлоготой, 241,97 сая төгрөгийн ББӨ тэй, үйл ажиллагааны зардалд 264,57 сая төгрөг, мөн санхүүгийн зардал 1084,02 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний ашиг 1021,35 сая төгрөг, нийт (38,68) сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Компани нь санхүүгийн тайлан баланс, болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар, агаарын бохирдлын албан

“БЭРХ УУЛ” ХК

татвар мөн нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь тогтмол гаргаж өгдөг.

2017 оны эхний хагас жилд төлсөн татвар, шимтгэлүүд:

1	Нийгмийн даатгалын шимтгэл	39.44
2	Агаарын бохирдолын төлбөр	12.70
3	АМНАТ	13.36
4	НӨАТ	54.49
5	ХХОАТ	25.69
6	Суутган 10	0.20
7	Бууны татвар	0.12
8	АТӨЯХАТ	0.66
9	Газрын төлбөр	0.08
10	ҮХХАТ	6.47
Нийт төлсөн татвар шимтгэлийн дүн		153.21

2017 оны эхний хагас жилд Чандганы хэсэг нь 11630 м3 хөрс цэвэрлэгээний ажил хийж 25406,5 тн нүүрс олборлон борлуулаад байна. Одоогийн байдлаар Чандганы хэсэгт Топазия ХХК-иар “Техник эдийн засгийн үндэслэл”-ийн нэмэлт тодотгол, Говь хангайн төгөл ХХК-иар “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ” зэрэг ажлуудыг хийлгэж байна.

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2016 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Khanate Resource Holding	51,8%
2	Khanate Resource Holdings-2 SARL	31,2%
3	BEU Holding S.A.R.L	10%
4	Khanate Resource Holding-3 SARL	6,6%
Нийт		99,6%

“БЭРХ УУЛ” ХК

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын мэдээлэл:

“Бэрх Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 сарын 24-ны өдөр хуралдаж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2017 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Уг хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 99,67 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2017 оны 06 сарын 02-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог М.Батсүрэн, Ж.Эрдэмбилэг, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Батсүрэнг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг, Т.Тамир, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Б.Пүрэвбаатар, Д.Нарангоо, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Пүрэвбаатарыг томилсон.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн дарга	дээд
2	Болд овогтой Мэндсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	дээд
3	Жэймс Пассин	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
4	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд

“БЭРХ УУЛ” ХК

5	Жүгдэрнамжил овогтой Эрдэмбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Батсүх овогтой Мянганбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Тэрбиш овогтой Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Дармаа овогтой Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Н.Батнайрамдал	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд